**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2026/124/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2026 оны 02 дүгээр сарын 16 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Н.Бүнчинсүрэн<br>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## НЭГ.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2026.02.23 № 2/28

танай________-ны № __________-т

БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА Д.БЯМБАСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд 9.5 тэрбум төгрөгийн өртөгтэй амбулаторийн 3 давхар барилга ашиглалтад орсон тул Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 02 дугаар сарын 20 оны өдрийн 86 дугаар тогтоолоор орлого авсан.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

6426050081

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-албан тоот.docx

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын вакум хагалгааны хэсэг засварын 763,128.8 мянган төгрөгийн ажил 2024 онд эхэлж 2025 оны байдлаар 711,375.3 мянган төгрөгийг санхүүжилт олгогдсон боловч дуусаагүй байна.

**Бусад асуудын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд нийт 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тус эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөл 85.2 хувийн биелэлттэй гэж үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийг "Улсын жишиг" болгох ажлын хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/37 дугаар тушаалын дагуу БНСУ-ын Hyundai Hospital болон Чун-Аны их сургуулийг түшиглэн 2025 оны 4 дүгээр сарын 14-нөөс 5 дугаар сарын 26-ны хооронд нийт 60 эмч, мэргэжилтнийг 4 ээлжээр сургалтад хамруулсан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

# ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,094,000,032.59** | **3,622,885,558.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 417,667,110.79 | 140,882,009.33 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 417,667,110.79 | 140,882,009.33 |
| **3121** | **Төгрөг** | 417,667,110.79 | 140,882,009.33 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 417,667,110.79 | 140,882,009.33 |
| **33** | **АВЛАГА** | 1,875,387,408.22 | 1,700,779,762.34 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 7,723,751.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 1,874,272,443.50 | 1,683,075,807.19 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 6,637,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,114,964.72 | 3,343,204.15 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,114,964.72 | 3,343,204.15 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 00.00 | 4,720,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 00.00 | 4,720,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,229,080,616.58 | 1,065,128,442.33 |
| **351** | **Түүхий эд материал** | 947,813,087.79 | 656,390,979.90 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 168,602,095.89 | 190,598,789.52 |
| 35130 | Эм боох материал | 779,210,991.90 | 465,792,190.38 |
| **354** | **Хангамжийн материал** | 281,267,528.79 | 408,737,462.43 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,385,740.00 | 6,992,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,289,315.40 | 3,955,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 4,065,420.25 | 3,937,616.40 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.02 | 00.03 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,274,500.00 | 18,909,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,389,000.00 | 1,097,050.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 265,863,553.12 | 373,845,596.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 571,864,897.00 | 711,375,344.00 |
| 36100 | Барааны нөөц | 571,864,897.00 | 711,375,344.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **15,373,038,338.84** | **24,905,690,109.22** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 15,373,038,338.84 | 24,905,690,109.22 |
| **392** | **Биет хөрөнгө** | 13,894,341,558.43 | 23,436,196,359.29 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,624,504,963.00 | 19,825,750,060.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -980,580,745.62 | -1,268,659,365.61 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,271,256,553.80 | 1,313,756,553.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -442,804,130.68 | -612,244,298.54 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 12,725,740,621.50 | 12,317,161,957.33 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -8,571,090,000.31 | -8,670,458,211.41 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 696,047,146.82 | 994,974,582.49 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -428,732,850.08 | -464,084,918.77 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,478,696,780.41 | 1,469,493,749.93 |
| 39301 | Програм хангамж | 81,457,022.00 | 87,457,022.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -50,585,241.59 | -65,788,272.07 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,447,825,000.00 | 1,447,825,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **19,467,038,371.43** | **28,528,575,667.22** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,596,673,106.80** | **1,609,345,354.47** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,596,673,106.80 | 1,609,345,354.47 |
| **413** | **Өглөг** | 1,596,673,106.80 | 1,609,345,354.47 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 889,003,821.08 | 865,528,205.31 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 690,405,585.72 | 724,295,508.16 |
| **4136** | **Бусад өглөг** | 17,263,700.00 | 19,521,641.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 7,763,700.00 | 19,521,641.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 9,500,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **17,870,365,264.63** | **26,919,230,312.75** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 17,870,365,264.63 | 26,919,230,312.75 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 6,725,816,344.70 | 6,725,816,344.70 |
| 51101 | Өмч: - төрийн | 6,725,816,344.70 | 6,725,816,344.70 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 8,285,188,897.91 | 17,342,314,802.03 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 8,285,188,897.91 | 8,304,144,174.91 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 9,038,170,627.12 |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,859,360,022.02 | 2,851,099,166.02 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **19,467,038,371.43** | **28,528,575,667.22** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **19,375,749,825.87** | **32,288,101,302.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,363,500,340.87** | **12,236,985,989.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,363,500,340.87 | 12,236,985,989.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,363,500,340.87 | 12,236,985,989.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 366,556,300.00 | 489,976,615.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 996,944,040.87 | 11,747,009,374.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **18,012,249,485.00** | **20,051,115,313.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 25,977,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 25,977,000.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 1,512,000,000.00 | 1,809,393,600.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 19,950,000.00 | 00.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 1,531,950,000.00 | 1,809,393,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 16,480,299,485.00 | 18,215,744,713.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 16,480,299,485.00 | 18,215,744,713.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **19,155,519,067.75** | **23,234,216,087.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **19,155,519,067.75** | **23,234,216,087.37** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 19,126,044,685.75 | 23,140,042,327.37 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 10,617,016,090.00 | 12,649,043,177.00 |
| 210101 | Үндсэн цалин | 5,582,278,011.00 | 6,479,107,316.00 |
| 210102 | Нэмэгдэл | 3,976,072,944.00 | 5,030,735,021.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 259,793,000.00 | 384,486,000.00 |
| 210104 | Урамшуулал | 798,872,135.00 | 754,714,840.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,374,745,201.96 | 1,630,142,834.96 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 937,495,843.72 | 1,103,263,884.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 108,577,159.68 | 129,554,395.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 77,475,612.38 | 100,852,383.06 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 50,070,107.74 | 59,048,791.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 201,126,478.44 | 237,423,380.54 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,290,890,720.17 | 1,701,492,266.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 144,423,148.17 | 198,196,531.04 |
| 210302 | Түлш, халаалт | 906,830,144.00 | 1,166,547,633.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 239,637,428.00 | 336,748,102.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 296,439,930.95 | 519,058,473.33 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,535,427.40 | 24,199,785.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 127,849,880.45 | 146,114,273.57 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,817,072.60 | 16,953,467.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 2,300,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 96,728,850.50 | 118,634,475.40 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 45,508,700.00 | 210,856,472.36 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,106,606,485.56 | 4,003,543,444.58 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,694,577,345.56 | 3,640,221,804.58 |
| 210502 | Хоол, хүнс | 373,611,640.00 | 363,321,640.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 38,417,500.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 121,529,520.00 | 149,827,063.85 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 784,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 120,745,520.00 | 149,827,063.85 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 31,468,200.00 | 44,435,320.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 31,468,200.00 | 44,435,320.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 314,597,951.50 | 279,611,542.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 266,644,843.50 | 226,338,492.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,200,000.00 | 3,200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 889,948.00 | 822,205.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 286,000.00 | 726,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,791,200.00 | 5,791,400.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 35,285,960.00 | 40,232,845.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,972,750,585.61 | 2,162,888,205.61 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 795,000.00 | 18,821,155.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,971,955,585.61 | 2,144,067,050.61 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,474,382.00 | 94,173,760.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,474,382.00 | 58,017,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 29,474,382.00 | 58,017,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 36,156,760.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 36,156,760.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **220,230,758.12** | **9,053,885,214.63** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 14,540,625.00 | 15,714,587.51 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 14,540,625.00 | 15,714,587.51 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -14,540,625.00 | -15,714,587.51 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **205,690,133.12** | **9,038,170,627.12** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **17,983,822,762.80** | **20,738,708,176.31** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **367,754,168.30** | **496,396,227.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 367,754,168.30 | 496,396,227.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 367,754,168.30 | 496,396,227.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 367,754,168.30 | 490,669,449.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,726,778.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **17,616,068,594.50** | **20,242,311,949.31** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 25,977,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 25,977,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,531,950,000.00 | 1,809,393,600.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 1,512,000,000.00 | 1,809,393,600.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 19,950,000.00 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 16,084,118,594.50 | 18,406,941,349.31 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 16,084,118,594.50 | 18,406,941,349.31 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **17,505,922,347.13** | **20,946,603,977.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **17,505,922,347.13** | **20,946,603,977.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **17,477,321,965.13** | **20,845,308,117.77** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 10,095,727,421.89 | 12,327,518,982.70 |
| 210101 | Үндсэн цалин | 4,811,748,035.89 | 5,663,827,858.70 |
| 210102 | Нэмэгдэл | 4,021,062,014.00 | 5,433,338,967.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 327,021,168.00 | 383,816,364.00 |
| 210104 | Урамшуулал | 935,896,204.00 | 846,535,793.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,598,179,945.40 | 1,970,386,415.97 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,237,225,545.40 | 1,490,918,115.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 90,238,600.00 | 119,867,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 72,190,900.00 | 59,933,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,047,700.00 | 59,933,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 180,477,200.00 | 239,734,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,512,000,036.00 | 1,731,356,140.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 144,423,148.17 | 198,196,531.04 |
| 210302 | Түлш, халаалт | 1,088,096,175.83 | 1,196,411,506.96 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 279,480,712.00 | 336,748,102.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 299,580,754.60 | 378,929,177.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 17,283,770.00 | 24,267,960.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 118,855,400.00 | 144,245,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,817,072.60 | 16,953,467.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 9,690,830.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,895,512.00 | 72,940,420.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 70,729,000.00 | 110,831,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 3,403,172,429.34 | 3,667,470,795.10 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,971,320,189.34 | 3,224,892,405.10 |
| 210502 | Хоол, хүнс | 391,793,740.00 | 361,208,390.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 40,058,500.00 | 81,370,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 116,988,486.40 | 350,794,707.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,176,000.00 | 23,170,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 7,375,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,044,000.00 | 468,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 107,768,486.40 | 319,781,707.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 31,660,200.00 | 44,435,320.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 31,660,200.00 | 44,435,320.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 419,217,691.50 | 328,535,425.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 371,503,543.50 | 266,365,320.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,200,000.00 | 3,200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 889,948.00 | 756,205.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 286,000.00 | 726,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 5,791,200.00 | 5,791,200.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 35,047,000.00 | 49,196,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 795,000.00 | 45,881,155.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 795,000.00 | 45,881,155.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,600,382.00** | **101,295,860.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,600,382.00 | 58,502,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 28,600,382.00 | 58,502,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 6,637,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 6,637,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 36,156,760.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 36,156,760.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **477,900,415.67** | **-207,895,801.46** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **65,134,610.00** | **68,889,300.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **65,134,610.00** | **68,889,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 65,134,610.00 | 68,889,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 65,134,610.00 | 68,889,300.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-65,134,610.00** | **-68,889,300.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 412,765,805.67 | -276,785,101.46 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 4,901,305.12 | 417,667,110.79 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 417,667,110.79 | 140,882,009.33 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 5,277,991,344.70 | 2,935,236,347.00 | -119,985,806.28 | 8,093,241,885.42 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,277,991,344.70** | **2,935,236,347.00** | **-119,985,806.28** | 8,093,241,885.42 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -110,448,584.16 | -110,448,584.16 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **6,725,816,344.70** | **2,859,360,022.02** | **8,285,188,897.91** | 17,870,365,264.63 |
| D01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **6,725,816,344.70** | **2,859,360,022.02** | **8,285,188,897.91** | 17,870,365,264.63 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 18,955,277.00 | 18,955,277.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **6,725,816,344.70** | **2,859,360,022.02** | **8,304,144,174.91** | 17,889,320,541.63 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -8,260,856.00 | 00.00 | -8,260,856.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 9,038,170,627.12 | 9,038,170,627.12 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **6,725,816,344.70** | **2,851,099,166.02** | **17,342,314,802.03** | 26,919,230,312.75 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,809,393,600.00** | **1,773,236,840.00** | **36,156,760.00** | 98.0% |
| Орон нутгийн төсвөөс | 1,809,393,600.00 | 1,773,236,840.00 | 36,156,760.00 | 98.0% |
| **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **18,931,692,000.00** | **18,406,941,349.31** | **524,750,650.69** | 97.2% |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 18,931,692,000.00 | 18,406,941,349.31 | 524,750,650.69 | 97.2% |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **1,118,822,800.00** | **496,396,227.00** | **622,426,573.00** | 44.4% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 701,103,700.00 | 490,669,449.00 | 210,434,251.00 | 70.0% |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,726,778.00 | -5,726,778.00 | 0.0% |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 417,719,100.00 | 00.00 | 417,719,100.00 | 0.0% |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **21,859,908,400.00** | **20,676,574,416.31** | **1,183,333,983.69** | 94.6% |
| **Ажиллагчидтай холбогдсон зардал** | **14,579,137,700.00** | **14,297,905,398.67** | **281,232,301.33** | 98.1% |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **12,608,751,200.00** | **12,327,518,982.70** | **281,232,217.30** | 97.8% |
| Үндсэн цалин | 6,463,890,000.00 | 5,663,827,858.70 | 800,062,141.30 | 87.6% |
| Нэмэгдэл | 4,670,812,400.00 | 5,433,338,967.00 | -762,526,567.00 | 116.3% |
| Унаа хоолны хөнгөлөлт | 439,560,000.00 | 383,816,364.00 | 55,743,636.00 | 87.3% |
| Урамшуулал | 1,034,488,800.00 | 846,535,793.00 | 187,953,007.00 | 81.8% |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,970,386,500.00** | **1,970,386,415.97** | **84.03** | 100.0% |
| Тэтгэврийн даатгал | 1,490,918,200.00 | 1,490,918,115.97 | 84.03 | 100.0% |
| Тэтгэмжийн даатгал | 119,867,100.00 | 119,867,100.00 | 0.00 | 100.0% |
| ҮОМШӨ-ний даатгал | 59,933,500.00 | 59,933,500.00 | 0.00 | 100.0% |
| Ажилгүйдлийн даатгал | 59,933,500.00 | 59,933,500.00 | 0.00 | 100.0% |
| Эрүүл мэндийн даатгал | 239,734,200.00 | 239,734,200.00 | 0.00 | 100.0% |
| **Бараа ,үйлчилгээний урсгал зардал** | **7,223,984,000.00** | **6,614,777,119.10** | **609,206,880.90** | **91.6%** |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,759,393,600.00** | **1,731,356,140.00** | **28,037,460.00** | 98.4% |
| Гэрэл, цахилгаан | 200,000,000.00 | 198,196,531.04 | 1,803,468.96 | 99.1% |
| Түлш, халаалт | 1,222,893,600.00 | 1,196,411,506.96 | 26,482,093.04 | 97.8% |
| Цэвэр, бохир ус | 336,500,000.00 | 336,748,102.00 | -248,102.00 | 100.1% |
| **Хангамж, бараа материалын зардал** | **380,915,000.00** | **379,429,077.00** | **1,485,923.00** | 99.6% |
| Бичиг хэрэг | 25,000,000.00 | 24,267,960.00 | 732,040.00 | 97.1% |
| Тээвэр, шатахуун | 147,000,000.00 | 144,245,000.00 | 2,755,000.00 | 98.1% |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,500,000.00 | 16,953,467.00 | -2,453,467.00 | 116.9% |
| Ном, хэвлэл | 12,000,000.00 | 9,690,830.00 | 2,309,170.00 | 80.8% |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,000,000.00 | 72,940,420.00 | -2,940,420.00 | 104.2% |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 112,415,000.00 | 111,331,400.00 | 1,083,600.00 | 99.0% |
| **Нормативт зардал** | **4,118,859,900.00** | **3,667,470,795.10** | **451,389,104.90** | 89.0% |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,612,183,000.00 | 3,224,892,405.10 | 387,290,594.90 | 89.3% |
| Хоол, хүнс | 427,176,900.00 | 361,208,390.00 | 65,968,510.00 | 84.6% |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 79,500,000.00 | 81,370,000.00 | -1,870,000.00 | 102.4% |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **497,135,200.00** | **411,669,207.00** | **85,465,993.00** | 82.8% |
| Багаж, техник, хэрэгсэл | 55,000,000.00 | 48,859,500.00 | 6,140,500.00 | 88.8% |
| Тавилга | 40,000,000.00 | 42,560,000.00 | -2,560,000.00 | 106.4% |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,000,000.00 | 468,000.00 | 532,000.00 | 46.8% |
| Урсгал засвар | 401,135,200.00 | 319,781,707.00 | 81,353,493.00 | 79.7% |
| **Томилолт, зочны зардал** | **50,167,000.00** | **44,435,320.00** | **5,731,680.00** | 88.6% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дотоод албан томилолт | 50,167,000.00 | 44,435,320.00 | 5,731,680.00 | 88.6% |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **367,513,300.00** | **334,535,425.00** | **32,977,875.00** | 91.0% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 297,679,300.00 | 272,365,320.00 | 25,313,980.00 | 91.5% |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0.00 | 100.0% |
| Даатгалын үйлчилгээ | 3,200,000.00 | 3,200,000.00 | 0.00 | 100.0% |
| Тээврийн хэрэгслийн татвар | 2,500,000.00 | 756,205.00 | 1,743,795.00 | 30.2% |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 842,800.00 | 726,600.00 | 116,200.00 | 86.2% |
| Газрын төлбөр | 5,791,200.00 | 5,791,200.00 | 0.00 | 100.0% |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 55,000,000.00 | 49,196,100.00 | 5,803,900.00 | 89.4% |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **50000000.00** | **45881155.00** | **4,118,845.00** | **91.8%** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 50,000,000.00 | 45,881,155.00 | 4,118,845.00 | 91.8% |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **56786700.00** | **40677000.00** | **16,109,700.00** | **71.6%** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **56,786,700.00** | **40,677,000.00** | **16,109,700.00** | **71.6%** |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 56,786,700.00 | 40,677,000.00 | 16,109,700.00 | 71.6% |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **21,859,908,400.00** | **20,953,359,517.77** | **906,548,882.23** | **95.9%** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | **417,667,110.79** | 0.00 | 0.0% |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | **140,882,009.33** | 0.00 | 0.0% |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 374 | 361 | 13.00 | 96.5% |
| Удирдах ажилтан | 2 | 2 | 0.00 | 100.0% |
| Гүйцэтгэх ажилтан | 301 | 293 | 8.00 | 97.3% |
| Үйлчлэх ажилтан | 71 | 66 | 5.00 | 93.0% |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **374** | **361** | 13.00 | 96.5% |
| Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 303 | 295 | 8.00 | 97.4% |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 71 | 66 | 5.00 | 93.0% |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **19,340,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **19,340,000.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 19340000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,340,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 19,340,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 19340000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 19,340,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,340,000.00 |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 105,192.6 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 3,100.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 61,431.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 40,661.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 105,192.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 37,058.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

1. Зүүн шанд ХХК 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоосон үнийг мөрдөх байтал 2025 оны 01 дүгээр сарын 1-ээс эхлэн мөрдсөнөөс шалтгаалж 3,100.1 мянган төгрөгийг илүү төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 57 дугаар хурлын тогтоолын 2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Илүү шилжүүлсэн 3,100.1 мянган төгрөгийг “Зүүн шанд” ХХК-ны 2026 оны халаалтын зардлаас суутган тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

1. Ази фарм ХХК-аас тайлант онд 224,138.2 мянган төгрөгийн эм авсан байхад цахим төлбөрийн баримтын системд 166,882.5 мянган төгрөгийг мэдээлж 57,255.6 мянган төгрөгийн И баримтыг дутуу мэдээлсэн байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6.”Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5. Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” заалтуудыг мөрдөөгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим төлбөрийн баримтын системд нөхөн мэдээлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн Б/27 дугаар тушаалаар Ёс зүйн хэсгийн хорооны дарга гишүүдэд 2,987.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө.", 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан хаагчдад үндсэн ажлын цалин хөлс, урамшууллаас гадна ажлын хөлс урамшуулал олгохгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

3. Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/260 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны 2024,2025 оны тендер шалгаруулалтын хорооны хөндлөнгийн гишүүнээр ажилласан гишүүдэд 1,188.1 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө.", 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад үндсэн ажлын цалин хөлс, урамшууллаас гадна ажлын хөлс урамшуулал олгохгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өмч хамгаалах зөвлөлтэй холбоотой асуудал

***Илрүүлэлт:*** Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн өмч хамгаалах зөвлөлийн байнгын зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөө баталсан боловч тухайн онд хийсэн ажлын тайлан байхгүй ба тайлант онд 11,692,433.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авсан байхад тухай бүр чанар байдалд нь үнэлэлт дүгнэлт өгөөгүй, авто тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэлд 40,661.3 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл авч сольсон байхад дүгнэлт гаргаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолоор батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 2.4-т "Өмч хамгаалах зөвлөл нь ажлын төлөвлөгөөг энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан загварын дагуу боловсруулж жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан хуулийн этгээдийн удирдлагаар батлуулж ажиллана." 3 дугаар зүйлийн 3.3-т "Өмч хамгаалах зөвлөл нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж, данснаас хасах зэрэг

эд хөрөнгийн зохицуулалт, төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж, дараах байдлаар зөвлөмж дүгнэлт гаргана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Тус байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг журмын дагуу ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Зүүн шанд ХХК 01 сарын 08-ны өдрөөс эхлэн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоосон үнийг мөрдөх байтал 1 сарын 1-нээс эхлэн мөрдсөнөөс шалтгаалж 3,100.1 мянган төгрөгийг илүү төлсөн байна | 1 | 3,100.1 | 1 | 3,100.1 | | | | |
| Ази фарм ХХК-аас тайлант онд 224,138.2 мянган төгрөгийн эм авсан байхад цахим төлбөрийн баримтын системд 166,882.5 мянган төгрөгийг мэдээлж 57,255.6 мянган төгрөгийн И баримтыг дутуу мэдээлсэн байна | 1 | 57,255.6 | | | 1 | 57,255.6 | | |
| Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн өмч хамгаалах зөвлөлийн байнгын зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөө баталсан боловч тухайн онд хийсэн ажлын тайлан байхгүй байна. | 1 | 40,661.3 | | | | | 1 | 40,661.3 |
| Дүн | 3 | 101,017.0 | 1 | 3,100.1 | 1 | 57,255.6 | 1 | 40,661.3 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн Б/27 дугаар тушаалаар Ёс зүйн хэсгийн хорооны дарга гишүүдэд 2,987.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна | 1 | 2,987.5 | 1 | 2,987.5 | | |
| Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Б/260 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны 2024.2025 оны тендер шалгаруулалтын хорооны хөндлөнгийн Гишүүнээр ажилласан Гишүүдэд 1,188.1 мянган төгрөгийг цалингийн сангаас олгосон байна. | 1 | 1,188.1 | 1 | 1,188.1 | | |
| Дүн | 2 | 4,175.6 | 2 | 4,175.6 | | |

------------oOo-------------